

Монгол хэлний хатуу, зөөлний тэмдэгийн тухай

Даваажавын УРТНАСАН*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн

Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын ЭШАА, доктор (Ph.D)

Хураангуй: Тус судалгаа монгол хэлний ‘цагаан толгой’-д хатуу, зөөлний тэмдэг гэж нэрлэдэг үсгүүдийн авианы шинжийг авиа зүйн ухааны өгүүлүүр, сонсол, дууны аргаар шинжилж зөв бичих зүй, үсэг зүйтэй холбон тайлбарлажээ. Тухайн үсгүүд авиалбар болж чадах эсэхийг тодруулахад зорьж, мөн тэмдэг болох үүргийг нь авч үзсэн байна. Үүний үр дүнд тэмдэг үсгүүд авиалбарын үүргээр үеийн цөм болдгийг нотолж, хатуугийн тэмдэг ялгах тэмдгийн үүрэггүй бол зөөлний тэмдэг ялгах тэмдгийн үүрэгтэйг тодорхойлжээ. Мөн хатуу, зөөлний тэмдэг огт үүрэггүй үеийн бүтцэд илэрч болдгийг харуулсан байна. Улмаар “Монгол үсгийн дүрэм” дэх ‘тэмдэг үсгүүд хоёр гийгүүлэгчийг тусгаарлах үүрэгтэй’ гэсэн тайлбарыг ахин авч үзэх шаардлагатай тухай санал дэвшүүлжээ.

Түлхүүр үг: тэмдэг үсэг, хатуугийн тэмдэг, зөөлний тэмдэг, ялгах тэмдэг, балархай эгшиг, гулсах авиа

Удиртгал

Монгол хэл гийгүүлэгч, эгшиг нийлсэн 63 авиалбартай. Эдгээрийг кирилл цагаан толгойн 35 үсгээр илэрхийлэх ба тэдгээрийн 2 нь тэмдэг үсэг юм. Тус бүрээр “хатуугийн тэмдэг”, “зөөлний тэмдэг” гэж нэрлэдэг¹.

“Монгол үсгийн дүрэм” (1983)-ийн 31, 32, 33, 34-р зүйлийг “Хатуу зөөлний тэмдгийн дүрэм” гэж гарчиглаад, тэмдэг үсгийг хэрхэн зөв бичих тухай зааж өгсөн байдаг. Тухайлбал.,

§ 31. Эр үгэнд орсон зарим гийгүүлэгчийг уг хэлэгдвэл зохих байраас нь урагшуулах, тагнайшуулах зэргээр хэлэхийг зөөлрүүлэх гэнэ. Жишээлбэл: бар-барь, хол-холь, ам-амь, зах-захь, тав-тавь гэх мэт.

* © Д.Уртнасан 2024

E-mail: urtnasand@mas.ac.mn

¹ § 2. Монгол бичиг 35 үсэгтэй. Эдгээр үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг гэж гурав хуваана. ...Цагаан толгойн үсгийн а, э, и, о, у, ө, ү, я, е, ё, ю, й, ы энэ арван гурав нь эгшиг, б, в, г, д, ж, з, к, л, м, н, п, р, с, т, ф, х, ц, ч, ш, щ энэ хорь нь гийгүүлэгч, ь, ь хоёр нь дуудлагагүй тул эгшиг ч биш гийгүүлэгч ч биш зүгээр тэмдэг үсэг болно. (Монгол үсгийн дүрэм, 1983: 405)

Эм үгийн гийгүүлэгч үсгүүд угаас тагнайшиж зөөлөн хэлэгддэг тул түүнд зөөлний тэмдгийг зөөлрүүлэх үүрэгтэй хэрэглэхгүй.

Зөөлөрсөн дан гийгүүлэгчийн ард зөөлний тэмдгийг бичнэ. Хэрэв давхар гийгүүлэгч зөөлөрвөл түүний ард “и” бичнэ. Жишээлбэл: морь, тахь, хонь, хонь, архи, орхи, тамхи, болхи, солби, дорви, анги гэх мэт.

§ 34. Тусгаарлагч ь, ь:

1. Эр үгэнд я, ё эгийг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдахаар орвол өмнө нь хатуугийн тэмдгээр тусгаарлаж бичнэ. Жишээлбэл: авъя, олъё, товъёг, угтъя гэх мэт.

2. Эм үгэнд е эгийг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдахаар орвол өмнө нь зөөлний тэмдгээр тусгаарлаж бичнэ. Жишээлбэл: өгье, узые, тэнцье гэх мэт. Я, е, ё, ю үсгүүд эгийг ба зөөлний тэмдгийн дараа залгаж ороход өмнө нь хатуу, зөөлний тэмдэг (ь, ь) бичихгүй. Жишээлбэл: саная, хичээе, олгоё, байя, хөгжсөөе, барья, орхиё, цохъё гэх мэт. (Монгол үсгийн дүрэм, 1983 :414-415)

Дээрх дүрэмд тус тэмдэг үсгүүдийн үүргийн (дан гийгүүлэгч зөөлөрснийг тэмдэглэх, хоёр гийгүүлэгчийг тусгаарлах гэх мэт) тухай зааж өгчээ. Энэхүү дан гийгүүлэгчийн зөөлөрснийг тэмдэглэнэ, хоёр гийгүүлэгчийг тусгаарлана гэсний тухай нарийвчлан авч үзэхээс гадна мөн “Монгол үсгийн дүрэм”-д ‘ь, ь’ хоёрыг дуудлагагүй тул ‘эгшиг ч биш гийгүүлэгч ч биш’ гэсэн ч үгийн бүтцэд үе бүтээж авиа, авиалбараар оролцдогийг авиа зүйн үүднээс нарийн нягт тайлбарлах шаардлагатай байна.

Үүний тул зөв бичих зүй ба зөв бичих дүрмийн ялгаа, зөв бичих зүй ба зөв дуудах зүйн холбоо хамаарлыг юуны түрүүн ялгаж салган ойлгох нь зүйтэй юм. Зөв бичих зүй нь үг, үеийн бүтцэд тулгуурлаж ингэж бичих нь зүйтэй гэдгийг судлан шинжилж, тэгж шинжилснийг зөв бичих дүрэм тогтоон журамлаж өгнө. Зөв бичих зүй нь авиа зүй, бүтээвэр зүйтэй, дүрэм нь үсэг зүйтэй нягт холбогдоно. Хэрхэн холбогдохыг хэл шинжлэлийн ухаанд үсэг зүй, авиа зүйн судалгааны аргаар судлан тогтооно. Үсэг зүй нь авиалбар болгонд нэг үсэг оноож тухайн хэлний цагаан толгойг зохиосон байдлыг судалдаг бол авиа авиалбар зүй нь авианы тогтолцоо, авиалбарын хувьсал, үеийн бүтэц хэлбэр, зөв дуудлагыг шинжилдэг.

Судалгааны зорилго

Монгол хэлний ‘ь, ь’ тэмдэг үсэг нь дуудлагатай бол авиалбар, харин дуудлагагүй бол тэмдэг болох юм. Хэрвээ ‘ь, ь’ -ийг авиалбар гэж үзвэл дууны онцлогийг нь тодруулах шаардлагатай. Улмаар үе бүтээх эсэхээр нь монгол хэлний үеийн бүтцэд томьёолон тусгах хэрэгтэй болно. Тиймээс энэ удаа хатуугийн тэмдэг, зөөлний тэмдгийн онцлог шинжийг авиа зүйн өгүүлүүр, сонсол, дууны аргуудаар шинжлэн тогтоохыг зорьсноос гадна зөв бичих дүрэмд туссан ‘ь, ь’ тэмдгийн ялгах, тусгаарлах үүргийн тухай үсэг зүйн үүднээс


харгалдуулан авч үзэх юм.

Тэмдэг үсэг ‘ь, ь’-ийн шинжлэл

Бүтэц 1:

[æ] гийгүүлэгч	↘	(хань [χæn])	↘	эр үг
[œ] гийгүүлэгч ь	—	(хонь [χœn])	—	
[ʏ] гийгүүлэгч	↗	(хунь [χʏn])	↗	

Бүтэц 1-ээс урагшилсан эгшгээс бүтсэн эр үгийн сүүлийн гийгүүлэгчийн хойно ямагт ‘ь’-ийг бичдгийг харж болно. Үүнийг зөөлөрсөн гийгүүлэгчийг² тэмдэглэсэн эсвэл гийгүүлэгчийг зөөлрүүлсэн гэх мэтээр тайлбарладаг бол урагшилсан эгшгүүдийг бие даасан авиалбар³ гэж үзээд ‘ь, ь’-ийг урагшилсан [æ, œ, ʏ] авиалбарыг урагшлаагүй а [a], о [œ], у [ʏ] авиалбараас ялгаж буй тэмдэг гэж үзвэл зохино⁴. Учир нь урагшилсан эгшгийн ард илрэх гийгүүлэгчүүд нь утга ялгах авиалбар биш ба дууны хувьд урагшлаагүй эгшгийн ард илрэх гийгүүлэгчээс төдийлөн ялгаагүй байдаг. Өөрөөр хэлбэл, ‘хань’ хэмээх үгийн ‘н(ь) [n]’ гийгүүлэгч ‘хана’ хэмээх үгийн ‘н [n]’ гийгүүлэгчээс ялгарах шинжгүй юм (Зураг 1).



Зураг 1. ‘хань’ [χæn] хэмээх үгийн солонгон бичлэг

Монгол үсгийн дүрмийг сайжруулахаар зорьж байсан тэртээх үед “Зарим хүмүүс зөөлний тэмдгийг нэгэнт бичсэн бол огт хувиргахгүй хэвээр бичих саналыг гаргаж байна. Энэ саналыг зөвшөөрвөл морьнд, арьхнд гэж бичих бөгөөд зөөлний тэмдэг зөөлрүүлэхээр барахгүй, и үсгийн үүргийг гүйцэтгэх болно. Тэгвэл одоо и, й, ы гурван зүйлийн и үсэгтэй байгаа бөгөөд түүний дээр зөөлний тэмдэг гэдэг и нэмэгдэж дөрвөн зүйлийн и үсэгтэй болно. Ингэвэл арай хэтэрнэ” (Монгол хэл бичгийн зарим асуудал, 1959 :12-13) гэх мэтээр үзэж

² мь, вь, рь, нь, ть, дь ... гэх мэт гийгүүлэгчийг тагнайшсан гийгүүлэгч (зөөлөрсөн гийгүүлэгч) гэж үзэн бие даасан авиалбараар тооцсон судалгаа бий. Гэвч сүүлийн үеийн туршилт судалгаанууд бие даасан авиалбараар тооцож авч үзсэнгүй.

³ 2022 онд гарсан “Монгол хэл судлал” 15 ботийн 8-рх “Авиа зүй” хэмээх нэг сэдэвт бүтээлд урагшилсан эгшгүүдийг бие даасан авиалбараар авч үзэн монгол хэлний авиалбарын бүрэлдэхүүнд оруулж тооцсон юм (2022 :31, 40).

⁴ Мөн адил ‘гавьяа, харьяа, томьёо, товьёг’ гэх мэт үгийн ‘ь’ урагшилсан эгшгийг тэмдэглэдэг бол биеийн хамаатуулах ‘минь, чинь, нь’-ийн ‘ь’ нь урагшилсан эгшгийг бус /п/ гийгүүлэгчийг тэмдэглэж байна. Энэ нь монгол хэлний зөв бичих дүрмээр утга зөөлний тэмдэг бус ялгах богино эгшиг байх ёстой юм.


байжээ. Үүнээс ‘зөөлний тэмдэг и үсгийн үүргийг гүйцэтгэнэ’ гэсэн нь анхаарал татаж байна. Тэрхүү и нь үгийн хоёрдугаар үеэс хойш илрэх учир балархай эгшгийг хэлж буй хэрэг юм. Үүнийг дараагийн Бүтэц 2-г өгүүлэх гулсах гийгүүлэгчийн өмнө илэрч үеийн цөм болж буй зөөлний тэмдгийн балархай эгшгийн үүрэгтэй адилтган үзэж болно.

Бүтэц 2:

ь	(үзье [utsəj] ⁵ , ирье [irəj])	эм үг + гулсах гийгүүлэгч [j]
ъ	(харья [χarəj], очъё [ɔtsʰəj])	эр үг

Эр, эм үйл үгийн араас захиран хүсэх утгатай үйлийн төгсгөх -я, -е, -ё нөхцөл залгахад эдгээр нөхцөлийн өмнө илрэх хатуугийн тэмдэг, зөөлний тэмдгийг хоёр гийгүүлэгчийг тусгаарлах үүрэг гүйцэтгэнэ гэдэг. Гэвч эдгээр нь үнэн чанартаа үе бүтээж буй эгшиг авиалбарууд байдаг. Үүнийг тайлбарлахын тулд эхлээд захиран хүсэх утгатай үйлийн төгсгөх -я, -е, -ё нөхцөлийн авианы бүтцийн тухай авч үзэх хэрэгтэй болно. Я-ийн төрлийн үсгүүд гэж нэрлэдэг, сүүлийн үед өгсөх хос эгшиг гэж үзэж буй эдгээр авиалбар нь энд дан бүтэцтэй илэрч байна. Өөрөөр хэлбэл эгшиг, гийгүүлэгчийн аль нэгнээр илэрч байна гэсэн үг юм. Учир нь хэлний авиаг гийгүүлэгч, эгшиг гэж хуваан авч үзсээр ирсэн ч гийгүүлэгч эгшгийн дундын шинжийг хадгалсан авиа байдаг. Тэрхүү авианы эгшигтэй холбогдох явц нь гулсамтгай учир гулсах авиа (glide) гэдэг. Зураг 2-ын эгшгийн формантын өмнөх хувьсамтгай хэсэг гулсах гийгүүлэгч (j)-ийг харуулж байна.


я /ja/



Зураг 2. Гулсах авиа дан эгшгээс бүтсэн /ja/ өгсөх хос эгшгийн солонгон бичлэг

Гулсах гийгүүлэгчийн дууны хөвчийн чичирхийллийн давтамж тогтмол, үндсэндээ эгшигтэй адил ч өгүүлэхүйн хөдөлгөөний өөрчлөлт маш хурдтай байдаг онцлогтой.

⁵ Ярианд [utsi:], [iri:], [χari:], [ɔtsʰi:] гэх мэтээр дууддаг.



Зураг 3. Гулсах авианы үе бүтээх шинжийн тухай схем (Лэдифогед, 2005 :227)

Зураг 3-аас гулсах авиа нь гийгүүлэгч эгшгийн шинжийг тэнцүү хадгалсан авиа гэдгийг харж болно. Гэхдээ ангилан авч үзэх шаардлагатай үед гийгүүлэгчээр авч үздэг байна. Тухайлбал, Бүтэц 2-ын жишээ дэх ү-зье [u-tɕɛ], ха-ръя [xa-rɛ] зэрэг үг нь ‘V.CVG’, ‘CV.CVG’ бүтэц бүхий хоёр үет үг юм⁶. Энд хатуугийн тэмдэг, зөөлний тэмдэг нь гийгүүлэгч (C), гулсах авиа (G)-аас бүтсэн ‘CVG’ үеийн цөм (V) буюу үе бүтээх эгшиг болж байна. Энэ эгшиг нь үргэлж тэргүүн бус үед тохиолдох учир балархай эгшиг юм. Үүнээс үеийн төгсгөл болох гулсах авиаг саланги дуудна гээд үеийн цөм болох ‘ь, ь’-ийг тусгаарлах үүрэгтэй хэмээн зөв бичих дүрэмд заасан нь ойлгомжгүй тайлбар болох нь харагдаж байна.

Бүтэц 3:

ь + өгсөх хос урт эгшиг (үзьюү [utsju:], биндэрьяа [pintərja:]) эм үг

ь + өгсөх хос урт эгшиг (харьюу [χarjo:], зурьюу [tsorjo:]) эр үг

Бүтэц 3-аас хатуу, зөөлний тэмдэг ямар нэг үүрэггүй тохиолдохыг харж болно. Өөрөөр хэлбэл, урагшилсан эгшиг авиалбарыг тэмдэглээгүй, мөн үгийн үе бүтээгээгүй байна. Тухайлбал, үз-ьюү [uts-ju:], хар-ьюу [χar-jo:], биндэр-ья [pin-tər-ja:] гэсэн эдгээр үг ‘VC.GV’, ‘CVC.GV’, ‘CVC.CVC.GV’ гэсэн үеийн бүтэц бүхий үгс юм. Зөвхөн зөв бичих дүрмийн дагуу эм үгийг зөөлний тэмдэгтэй, эр үгийг хатуугийн тэмдэгтэй бичдэг байна.

Дүгнэлт

Зөөлний тэмдэг урагшилсан эгшгийг тэмдэглэж байгаа нь үсэг зүйн асуудал бөгөөд үүнтэй мөн адил үүргийг урагшилсан эгшгийн ард илрэх давхар гийгүүлэгчийн арын и эгшиг гүйцэтгэдэг байна. Зөөлний тэмдгээр төгссөн эр, эм үгийн араас гулсах гийгүүлэгч ‘j’ ороход зөөлний тэмдэг нь үе бүтээж

⁶ Дээрх байдлаар задлан шинжилсний эцэст “Үеийн тухай, үг шилжүүлэх дүрэм: 45.2. Хатуугийн тэмдэг, зөөлний тэмдгийг өмнөх гийгүүлэгчийг дагуулан үелнэ. Жишээлбэл., үз-е, ха-рууль-я гэх мэт. (Монгол үсгийн дүрэм, 1983 :419)” хэмээх хэсэг монгол хэлний үеийн бүтцийг зөрчсөн болохыг мэдэх ба үеийн тухай ахин задлан шинжлэх шаардлагатайг илэрхийлнэ.

балархай эгшгээр илэрнэ. Энэ нь зөөлний тэмдгийн авианы шинж юм. Гэтэл эм үгэнд өгсөх хос урт эгшгийн өмнө зөөлний тэмдэг орох тохиолдолд үсэг болоод авианы ямар ч үүрэггүй байна.

Хатуугийн тэмдэг зөвхөн эр үгэнд гулсах гийгүүлэгчийн өмнө л илрэх ба энэ тохиолдолд зөөлний тэмдэгтэй адил үе бүтээж балархай эгшгээр илэрнэ. Энэ нь хатуугийн тэмдгийн авианы шинж юм. Харин эр үгэнд өгсөх хос урт эгшгийн өмнө хатуугийн тэмдэг орох тохиолдолд үсэг болоод авианы ямар ч үүрэггүй байна.

Зөөлний тэмдэг ялгах үүрэгтэй ч, хатуугийн тэмдэг нь ялгах үүрэггүй. Үүгээр зогсохгүй “Монгол үсгийн дүрэм” дэх ‘тэмдэг үсгүүд хоёр гийгүүлэгчийг тусгаарлах үүрэгтэй’ гэсэн ойлгомжгүй тайлбарыг энд өгүүлж буй тэмдэг үсгийн үе бүтээх авианы шинж, урагшилсан эгшиг авиалбарыг ялгах шинжид тулгуурлан ахин авч үзэж зохих юм.

Summary

This research deals with the phonetic features of the hard and soft signs in the Mongolian alphabets, by analyzing the articulatory, auditory, and acoustic methods, and related them to orthography and graphemics. It aims to clarify whether signs can become phonemes, and the role of signs is clarified. Therefore, it is proved that the two characters are the core of generation due to their phonetic function, and it is determined that the hard sign is not diacritic, and the soft sign is diacritic, and it is also determined that they appear in the word structure without any role. As a result, it was suggested that the explanation “Sign letters are responsible for separating two consonants” in the “Mongolian orthography” should be revised.

Keywords: sign letter, hard sign, soft sign, ялгах тэмдэг, reduced vowel, glide

Ном зүй

- Дамдинсүрэн, Ц., Осор Б.** (1983). *Монгол үсгийн дүрмийн толь*, Улаанбаатар.
[Damdinsuren, Ts., Osor, B. *Mongol usgiin durmiin toli*. [Orthography dictionary of Mongolian] Ulaanbaatar. 1983.]
- Лувсандэндэв, А.** (ред.), (1959). *Монгол хэл бичгийн зарим асуудал*, Улаанбаатар.
[Luvsandendev, A. (red.), *Mongol khel bichgiin zarim asuudal*. [Some issues of Mongolian] Ulaanbaatar. 1959.]
- Уртнасан, Д., Батдорж, Ц., Батхишиг, С.** (2022). *Монгол хэл судлал- Авиа зүй*, 8-р боть, Улаанбаатар: Соёмбо принтинг. [Urtnasan, D., Batdorj, Ts., Batkhishig, S. *Mongol khel sudlal-Awia zui*. [Mongolian Language Studies, Volume VIII, Phonetics and Phonology] Ulaanbaatar. Soyombo Co. Ltd. 2022.]
- Ladefoged, P. N.** (2005). *A Course in Phonetics* (5nd ed.). Harcourt Brace Jovanovich: New York.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.